

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ УДИРДЛАГА

*Ц.Бямбарагчаа - ХСПС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага,
стратегийн профессорын багийн профессор, доктор
(PhD), хурандаа*

УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТҮҮХИЙН АСУУДАЛ

Хураангуй. Нийгмийн хөгжил дэвшилтэй уялдан хязгааргүй өсөн нэмэгдэж буй нийгэм болон түүний гишүүдийн хэрэгцээг хангах төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай хязгаарлагдмал нөөцүүдийг үр ашигтай хуваарилах, ашиглах тухай асуудлыг эдийн засгийн онолоор судалдаг.

Нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалаар дээрхи хязгааргүй өсөн нэмэгдэж хэрэгцээг хангахад хэрхэн дэмжлэг үзүүлж ирсэн талаар Улсын нөөцийн удирдлага зохион байгуулалтын түүхэн баримтыг үндэслэн хөндөж тавихыг зорилоо.

Түлхүүр үг. Нөөц, улсын нөөц, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, зах зээлийн эдийн засаг

Монгол угсаатан бүрэлдэн тогтсон үеэс эхлэн төр улсын байгууллага институт бий болж, 2200 гаруй жилийг туулан ирсэн түүхэн уламжлал улсын нөөцийн үүсэл хөгжил, удирдлага зохион байгуулалттай салшгүй холбоотой.

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн түүхийн урт удаан хугацаанд хоол тэжээлээ олж идэх, өөрийн оршин тогтнож буй байдлаа баталгаажуулахын төлөө цаг ямагт хүч тавьж багагүй ухаан зарцуулж ирсэн билээ.

Нийгмийн хөгжлийн эхэн үед хүн өөрийнхөө хоол тэжээлд гол анхаарлаа тавьж байсан бол дараачийн шатанд хоол тэжээлийн эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариаланд анхаарал тавих болжээ.

Хаант засаглалын үед нэг өрх гэрийн асуудал болсон хоол тэжээл маань улс гэрийн, улмаар бүх нийтийн асуудал болж ард иргэдээс алба гувчуур авах, татвар хураах замаар хааны сан хөмрөг болон хувирсан түүхтэй. Хаан энэ сан хөмрөгөө ард түмнээ ядуурсан, дайн самуунд өртөж улс орон хүнд байдалд орсон үед гарган хэрэглэх тооцоог хийсэн байсан нь хэн бүхэнд ойлгомжтой асуудал юм.

Ялангуяа эрс тэс уур амьсгалтай, нүүдэлчний соёл иргэншилтэй монголчуудын хувьд хоол тэжээлээ хадгалах, нөөцлөх арга ухаан өөрийн гэсэн онцлогтой байжээ. Эзэн Чингисийн үеэс дайн байлдаанд оролцох, улс гэрээ хамгаалах жин тээх үед урт хугацаагаар хадгалалт даах борц, ааруул арвайн гурил, цай, тос зэргийг бэлтгэн хүн тус бүрт тодорхой хэмжээ тогтоон авч явдаг байжээ. Мөн хааны торгон сүрэг гэж тусад нь үржүүлж төрийн хэрэгт түлхүү ашиглах бодлого барьж байсан нь түүхийн зарим нэг эх сурвалжаас харагддаг.

Ляо улсын түүхэн бичигт Хятан нарын заншил бол адуу мал нь өвс усыг дагаж бэлчээрлэх бөгөөд хүн нь мэргэн харвах явдлаар амьдарлын зорилго болгож малаас гарах ашиг шимийг эрхэмд үзэж, өнөө хүртэл малын махыг өвөл намар нь борцолж хатаагаад хавар хүнс цагаан идээ тарчиг үед гаргаж хэрэглэдэг. Халимагийн эрдэмтэн Эрэнжен Хара-Даван, “Хоол хүнсний нөөц дууссан үед монголчууд моринхоо судсыг ханаж цусыг нь хэсэг уугаад дараа нь хүлгийнхээ шархыг боож тогтоодог байлаа. Хүний гэдэс цадахад хагас литр цус л хангалттай байдаг бол морины хувьд, ялангуяа хөтөлгөө морины хувьд төдий хэрийн цус огт нөлөөлөхгүйгээс гадна маш бага хугацаанд нөхөгддөг” гэсэн байна. XIX зууны сүүлхэн үеэр манай орноор зорчсон оросын эрдэмтэн Г.Н.Потанин халхын олон нутагт мэхээр цуглуулж байсныг сонирхон үзэж, “мэхээрийн орд” олох арга, нэг нүхнээс авах мэхээрийн хэмжээ зэргийг тодорхой дурдсан байдаг. Мөн гичгэнэ хэмээх ерөнхий нэрээр олон зүйл гичгэнийг нэршиж заншсан боловч тэдгээрийн дотроос халуун гичгэний үндсийг ямаахайн үндэсний адил сүүнд загсаах, тосонд холих, мах шөлтэй хоолонд холих гэж нөөцлөн түүж байжээ. Говь нутгийн халхчууд гурил, будааг орлуулж сулхир, шар мод, суль зэрэг зэрлэг үр, амууг их хэмжээгээр нөөцөлж байсан нь тэдгээр ургамлыг түүж хураах, цайруулж боловсруулахтай холбоотой аж ахуйн арга барил, мэдлэг ихээхэн баялаг. нарийн дэс дараатай болгосныг тэмдэглэвэл зохино гэжээ.

Манжийн байлдан эзлэгчдийн эрхшээлд 1691-1911 он хүртэл 200 гаруй жил байсан нь Монголын ард түмний түүхэнд хамгийн хүнд үе байж, Монголын ард түмний эдийн засаг, соёл, боловсролын хөгжлийг асар ихээр саатуулсан үе байсан. Монгол улсын 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд бий болсон туурга тусгаар улсын сан хөмрөгийг зузаатгах, бэхжүүлэхэд амиа аргацаасан мал аж ахуйтай, өөрийн гэх үйлдвэр, олигтой худалдаа, үндэсний мөнгөн тэмдэгт байхгүй, мэргэжлийн ажилтан нараар дутмаг байсан нь тухайн үеийн улс орныг өөд нь татах, санхүүгийн үндэсний системийг бий болгоход хүндрэл бэрхшээл тулгарсан байдаг. Сангийн яам сангийн мөнгийг хадгалах, улсын төсвийн орлого, зарлагын

төсөв зохиох мөнгөний тооцоог нарийн хийх, хөтлөн данслах, улсын эрдэнэсийн санд хадгалж буй алт. мөнгө зэрэг унэт зүйлийн үнэлгээ. хадгалалт. зарцуулалтанд хяналт тавих зэрэг ажил эрхэлж байсан. Тухайн үед манай оронд бүдүүлэг ажиллагаатай нүүрсний ил уурхай, тоосгоны завод, хэвлэлийн газар, утсан харилцаатай газар, цахилгаан станц, дарханы газар, зэвсэг засвар зэргийн үйлдвэрийн газрууд байгуулагдаж байсан ба газрын баялгыг ашиглах. гадаадын капитал орж ирж байсан боловч эдгээрийн үр дүнгээр төсвийн орлого бий болохгүй, санхүүгийн нөөцөөр тун хомс байсан байна. Улсын санхүүг бэхжүүлэхэд бололцоотой бүхий л нөөц боломжийг ашиглахыг урьтал болгон ажиллаж нэгдүгээрт албан татварын (1912 оноос) тооцооны уламжлалыг өөрчлөн улсын бүх албыг суман эрийн тоонд ногдуулан хураадаг байсныг халж малын тоо толгойд тооцох болсон, гадаадын харьяат нарын визний хураамж, уурхай ашиглах, тариалангийн талбай, малын бэлчээр эзэмшсэний түрээс, агнуурын татвар, хоёрдугаарт, малын хөлийн татвар, дотоод, гадаадын гааль, газрын татвар, уурхайн татвар дотроо гурван хураамж бүхий нэг татвартай болсон байна. Эдгээр татвараас уурхайн татвар улсын сан хөмрөгт хамгийн дорвитой хувь нэмэр оруулж байсан байна.

1911-1919 он хүртэлх санхүүгийн төсвийн гол эх сурвалж нь гааль татвар хураамж. уул уурхай, худалдаа, гадаадаас орж ирсэн зээл тусламж байсан нь тус улсын төсөв байнгын алдагдал хомсдолтой байсан нь санхүүгийн системийн тогтолцоо төлөвшиж чадаагүйтэй холбоотой байсан. 1919 онд Монгол улсын автономит эрхийг Хятадын милитаристууд устгахад үндэсний эрх чөлөөний тэмцлийн шинэ давалгаа өрнөж, тэмцлийг манлайлж байсан улс төрийн хүчин болох МАН-ын зорилгод үндэсний худалдааны салбарт хоршооллыг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийг өөд татан. алсдаа эдийн засгийн тусгаар тогтнолоо олох зорилго агуулагдаж байсан гэж үздэг байна.

Социалист системийн үед улсын нөөцийн гүйцэтгэх үүрэг. ач холбогдлыг өндөрт тавьж гишүүн орон бүр нөөцийн яам, хороотой байсан бөгөөд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын улсын нөөцийн байгууллагын удирдлагуудын зөвлөлгөөнийг хоёр жил тутамд хийж байжээ. Уг зөвлөлгөөн Улаанбаатар хотод хоёр ч удаа зохиогдож байсан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн маш нууц 244 дүгээр тогтоолоор "Өргөн хэрэглээний барааны улсын нөөц байгуулах тухай" үүргийг тухайн үеийн Худалдаа. бэлтгэлийн яам, Гадаад худалдааны яаманд үүрэг болгосноор улсын нөөцийн хүнс. өргөн

хэрэглээний бараа, материал хуримтлуулах албан ёсны эрх зүйн үндэслэл бий болж улсын нөөцийн асуудал хариуцсан тусгайлсан албатай болсон байна.

Улсын нөөцийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоох, бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, зарцуулах, төвлөрүүлэн удирдах хариуцлагатай үүргийг 1977 оноос БНМАУ-ын Улсын төлөвлөгөөний комиссын Улсын материал-техникийн хангамжийн хороонд улсын дайчилгааны нөөц хариуцсан Тусгай хэлтэс, 1981 оноос Материал-техникийн хангамжийн улсын хороо, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөс хамааран 1988 оноос Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яам, 1990 оноос Худалдаа, хамтын ажиллагааны яамны Тусгай хэлтэс, Худалдаа, үйлдвэрийн яамны Үйлдвэр, техникийн хэлтэс тус тус хариуцан ажиллаж байв.

1990-ээд онд Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилсэнээр ЗХУ болон социалист орнуудтай хийж байсан худалдаа, ялангуяа бартерийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа бүрмөсөн зогссон үед эдийн засаг хямралд орж ард түмэнд хүндээр тусч, 1990 оны эхнээс дэлгүүрийн лангуу хоосорч улсын нөөцийн хүнсний барааг ард иргэдэд Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгуудад картаар олгодог болсноор Улсын нөөцөөс тусламж аваагүй иргэн, үйлдвэр, аж ахуйн нэгж, төрийн байгууллага ховор болсон байна.

Монгол улс 1991 -1993 оны хооронд картын системд шилжиж өрх бүрт 11 нэрийн бүтээгдэхүүн картаар өгч байсан бөгөөд 1 хүнд сард 3 кг гурил, элсэн чихэр, цагаан будаа тус бүр 550 грамм, цөцгийн тос 350 грамм, нэг өрхөд ургамлын тос 1 литр, талх өдөрт 1 ширхэг, архи 2 шилийг картаар олгож байсан байна. Монгол Улсын Их Хурлын 1996 оны 40 дүгээр тогтоол, Засгийн газрын 1996 оны 314 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын нөөцийн газар (хэрэгжүүлэгч агентлаг)-ыг 1996 оны 9 дүгээр сарын 20-нд байгуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 01 тоот тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрын Улсын нөөцийн газар, 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар "Гамшгаас хамгаалах тухай" хуулийг шинэчлэн, боловсронгуй болгож баталсаны үндсэн дээр Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газар хариуцан ажиллаж байгаад Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 4 дүгээр тушаалаар Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар нэртэйгээр

улсын нөөцийг удирдлага, зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах зорилттой үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүгнэлт

Ард түмний дунд “үрээ идэхээс үрээгээ ид”, “айлаас эрэхээр авдраа уудал” гэдэг эрхэм сургаал үгийг Монголчууд эртнээс мөрдөж ирсэн түүхэн уламжлал нь эзэн Чингисийн цэрэг дайчдын хоол хүнс, хуурай хэрэгслийг нөөцлөх, түүнийг боловсруулах арга зэрэгтэй холбоотой.

Улс орны оршин тогтнохын нэг гол хүчин зүйл нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хараат бус байдал юм. Улсын нөөц нь энэ 2 ойлголттой шууд хамааралтай байдаг.

Нөөцийн ач холбогдлын талаар тодорхой шинжлэх ухааны тайлбар байхгүйгээс зарим хүмүүс улсын материаллаг нөөц байх шаардлагагүй гэсэн ойлголт байдаг. Гэхдээ өнөөдрийн байдлаар хөрш хоёр орны зах зээлээс хараат байдалтай, дэд бүтцийн хөгжил харьцангуй сул, хүн амын дийлэнхи нь байгаль цаг уурын нөхцлөөс хамааралтай нүүдлийн мал аж ахуйн эрхлэн амьдардаг, дэлхийн зах зээлийн экспортын цөөн нэр төрлийн барааны үнийн өөрчлөлтөөс эдийн засаг нь хамаарч байдаг, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл сул манай орны хувьд улсын нөөцийн бараа, материал хуримтлуулан хадгалах шаардлага зүй ёсоор гарч байгаа юм.

Дэлхийн улс орнуудын хувьд ч гэсэн Улсын нөөцдөө чухал ач холбогдол өгч байсан ба том жижиг олон осол, гамшиг, дайн байлдаан зэргээс сургамж авч нөөцийн асуудлаа улам боловсронгуй болгож чанд нууцалж ирсэн бөгөөд Улсын нөөц нь тухайн орны хүчин чадлыг илэрхийлэх нэг гол үзүүлэлт гэж үздэг.

Санал

Монгол Улсын түүхэнд улсын нөөц нь ялангуяа эдийн засгийн хөгжилт бэхжилтийн асуудалд чухал байр суурийг эзэлдэг бөгөөд улсын нөөцийн түүх нь цаг хугацааны хувьд Монгол Улсын түүхийн эрт үеэс эхлэдэг нь ойлгомжтой юм. Гэвч улсын нөөцтэй холбогдох баримт материалууд нь Улсын нууцад хамаарагдах учир судалгааны эргэлтэнд оруулах асуудал хаалттай байсаар ирсэн бөгөөд өнөөдөр ч ийм нөхцөл байдалтай байна.

Монгол Улсын Үндэсний төв архив, Засгийн газрын архив, Тагнуулын тусгай архивын сан хөмрөгт улсын нөөцөд холбогдох ХХ зууны эхэн болон дунд үеийн буй зарим баримтууд хадгалагдаж байдаг.

Цаашид Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааны улсын нууцад хамаарагдах хугацаа дууссан буюу улсын нууцад хамаарагдахааргүй үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаар хэвлэн нийтэлж, олны хүртээл болгон ашиглаж байх нь эрдэм шинжилгээний болон практик, судалгаа зэрэг олон талын ач холбогдолтой байна.